



ГАЛТ ТЭРЭГНИЙ ХӨДӨЛГӨӨН ЗОХИЦУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨВ



E-NEWSLETTER

f [facebook.com/Rtcc.m0n](https://www.facebook.com/Rtcc.m0n)
🌐 <http://rtcc.mrtcd.gov.mn>
✉ info@rtcc.mrtcd.gov.mn
☎ +976 77244409

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2019 оны есдүгээр сарын дугаар

Хамтын ажиллагаа



Төмөр замын хамтын ажиллагааны байгууллагын Тээврийн бодлого хөгжлийн стратегийн комиссын “Төмөр замын тээврийн статистикийн асуудлаарх мэргэжилтнүүдийн зөвөлгөөн”-нд оролцлоо.

ТЗХАБ -ын Тээврийн бодлого хөгжлийн стратегийн комиссын “Төмөр замын тээврийн статистикийн асуудлаарх мэргэжилтнүүдийн зөвөлгөөн”-ийг Тээврийн бодлого, хөгжлийн стратегийн 1 дүгээр комиссын дарга Цухрат Каюмхаджаев удирдан энэ сарын 17-20-ний өдрүүдэд Улаанбаатар хотод болж өндөрлөлөө.



Зөвөлгөөнд тус байгууллагын 16 орны 27 төлөөлөл оролцож, гишүүн орнууд ажлынхаа гүйцэтгэлийг ярилцаж, тухайн орон аль чиглэлд ачаагаа экспортолсон, ямар чиглэлээс импортлосон, тухайн замаар аль орны ачаа ямар хэмжээгээр тээвэрлэсэнийг тулгалт хийж гишүүн орнуудын хувьд тээвэрлэлт нэг ижил тоотой, хоорондын зөрөөгүй, тээвэрлэсэн ачааны хэмжээ, нэр төрөл зэргээр харилцан мэдээллээ солилцсон арга хэмжээ боллоо.

Зөвлөгөөнөөр гишүүн орнуудын төмөр замын стратегийн хөгжил, тээврийн



статистикийн үзүүлэлтийг авч хэлэлцэн нэгтгээд дүгнэлт хийж, одоогийн байдлыг тодорхойлж, цаашид илүү анхаарах асуудлыг ярилцан, хамтын ажиллагааг өргөжүүлэх бодлогыг ярилцаж, хурлын үр дүнд зөвшилцөн, баталгаажуулж бүгд хүлээн зөвшөөрсөн товхимол гаргалаа.



Монгол улсын төмөр замын статистик судалгааны салбар бусад улс оронтой ижил түвшинд ажиллаж, цаасгүй технологи нэвтрүүлж байгаа нь оновчтой боловсронгуй болж байгаагийн илрэл гэж харлаа хэмээн хурлын дарга Шухрат Каюмхаджаев цохон тэмдэглэлээ.



Төвийн үйл ажиллагаа



Төвийн болон албан хаагчийн ёс зүйн дүрмүүд шинэчлэгдэн, хуулийн төслийн ажлын тайланг ЗТХЯ -нд хүргэж танилцууллаа.


Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд нийцүүлэн "ГТХЗНТ" УТУГ-ын ажилтны ёс зүйн дүрмийг төвийн захирлын 2019 оны А/59 дүгээр тушаалаар шинэчлэн батлав.

Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох ажилд дэмжлэг үзүүлж Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах санал боловсруулж ЗТХЯ-нд хүргүүллээ.

ЗТХ-ийн сайдын 2017 оны 259 дүгээр тушаалын 3-р хавсралтын дагуу харьяа байгууллагын тогтмол гаргах тайлан, мэдээллийн нэр төрөл, хугацааны 3.5, 3.7, 3.10-т заасан хууль тогтоомж, тогтоол шийдвэр, сайдын тушаалаар болон сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2019 оны III улирлын байдлаар гаргаж яамны ХШУДАГ, ТЗУГ-т тогтоосон хугацаанд хүргэж тайлагнав.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 105 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсгээс "ГТХЗНТ" УТУГ-ын 2017-2018 оны санхүүгийн болон үйл ажиллагааны үр дүнд хийгдсэн хяналт, шалгалтын зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, биелэлтийг яамны ХШУДАГ-т хүргүүлж танилцуулав.

ЗТХ-ийн дэд сайдын 2019 оны "Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай" албан бичгээр өгсөн үүрэг даалгавар болон зам, тээврийн салбарын үйл ажиллагааг сурталчлах нээлттэй өдөрлөгөөр "ГТХЗНТ" УТУГ-аас зохион байгуулсан ажлын тайланг яамны ТЗУГ-т хүргэж танилцууллаа.





БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /КОЙКА/ -ээс судалгааны баг ирж төмөр замын өнөөгийн нөхцөл байдал, суурь судалгааг ГТХЗНТ УТУГ, УБТЗ ХНН, МТЗ ТӨХК -д хийлээ.

БНСУ-ын “КОЙКА” олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгт “Төмөр замын бодит цагийн мэдээллийн нэгдсэн систем хөгжүүлэх, үүнд шаардлагтай техник технологи суурилуулалтын орон зай /барилга/-г бий болгох хүсэлт” PCP /project concept paper/ төслийн үзэл баримтлалын баримт бичгийг боловсруулан КОИКА-ын Монгол дахь төлөөлөгчийн газарт хүргүүлсэн бөгөөд КОИКА -аас судалгааны баг ирж төсөл хэрэгжих шаардлагатай эсэхийг тодорхойлох, төмөр замын өнөөгийн нөхцөл байдал, төсөл хэрэгжих байршилтай танилцан, суурь судалгааг ГТХЗНТ УТУГ-тай хамтарч хийлээ.



Төсөл хэрэгжүүлэхдээ холбоотой 09-р сарын 16-20 өдрүүдэд Зам, тээврийн хөгжлийн яам, Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв, Монголын төмөр зам ТӨХК, Улаанбаатар төмөр зам ХНН, БТЕГ ХХК зэрэг төмөр замын байгууллагуудад судалгаа хийсэн




Шинэ технологийн судалгаа



“Уул уурхайн төмөр замын хүнд даацын хөдлөх бүрэлдэхүүний шилдэг техник технологиуд”

Уул уурхайн төмөр замуудад хүнд даацын техник ашиглаж байгаа бүсүүд



Уул уурхайн төмөр замууд хүнд даацын Америк гаралтай, Америк технологийн илчит тэрэгнүүд ашиглаж байна.
(Тэнхлэгийн даралт > 30 тонн, чадал > 4200 м.х)

Хойд Америкт уул уурхайн тээвэр хийх шаардлага байсан нь АНУ дизель татлагад тулгуурласан төмөр замыг хөгжүүлэх үндэс суурь болсон бөгөөд уул уурхайн тээвэр хийх хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хойд Америк, өмнөд Америк, Австрали тивд АНУ-ын технологийг нэвтрүүлжээ. Мөн өмнөд Африк, Арабын орнуудад ийм хандлага бий.

АНУ-ын энэ технологи нь зүтгүүрийг өндөр үр ашигтай, бүтээмжтэй ажиллах нөхцлийг бүрдүүлж, үйл ажиллагааны бүх чиглэлд ашгийг нэмэгдүүлэхэд зохицсоноос уул уурхайн тээвэр хийхээр зэхэж буй улс орнууд энэ технологи, ажиллах арга барилыг авч нэвтрүүлж байна.

Байгаль орчны асуудлыг онцгой анхаарч, байгаль орчны бохирдолтыг бууруулах шинэ стандартын шаардлагыг даган хөдлөх бүрэлдэхүүн улам сайжирсаар байна.

Сүүлийн үед Австрали улс энэ технологийг харьцангуйгаар илүү ашиглан, тээврийн технологийн салбарт тэргүүлэгч улс болж байна.

Бага хэмжээний тээвэр гүйцэтгэх орчин үеийн, цахилгаан зүтгүүртэй хүнд даацын тээвэр Скандинавын хойгт байгуулагдсан. Энэ нь 30 тонн тэнхлэгийн даралттай IORE цахилгаан зүтгүүртэй төмрийн хүдэр зөөх төмөр зам юм.



“Уул уурхайн төмөр замын хүнд даацын хөдлөх бүрэлдэхүүний шилдэг техник технологиуд”



Евро-Азид нэвтэрсэн Америк илчит тэрэгнүүд (>4000 м.х)

EMD : Central Europe - Euro 4000,
China – JT56Ace,
India – GT46MAC

GE : Belarus – TE33A,
Kazakhstan – TE33A,
China – ES59Ac1,

Евро-Азид дээд тал нь 25 тн тэнхлэгийн даралттай, өндөр чадалтай Америк илчит тэрэгнүүд нэвтэрч байна.



Цахилгаанжуулсан төмөр зам хөгжсөн баруун Европ болон Япон улсад уул уурхайн төмөр замын тээвэр хийх шаардлагагүй байснаас хүнд даацын цахилгаан зүтгүүртэй тээвэр хөгжөөгүй байна.

ОХУ, БНХАУ зэрэг улсууд уул уурхайн тээвэрт цахилгаан болон дизель зүтгүүр ашиглаж байгаа боловч тэнхлэгийн даралт 25 тн-оос хэтрээгүй, технологийн хөгжил дутмагдуу байна.

Шинэ технологийн судалгаа



“Уул уурхайн төмөр замын хүнд даацын хөдлөх бүрэлдэхүүний шилдэг техник технологиуд”

Уул уурхайн төмөр замын хүнд даацын хөдлөх бүрэлдэхүүн, зүтгүүрт гарах өөрчлөлтүүд стандартад тусгагдсан байдал

ЕСРВ - Цахилгаан удирдлагат хийн тоормос

Rotary coupler for dumping - Вагон хөмрөг буюу эргэдэг автоугсраа

Distributed Power for multiunit system – Олон зүтгүүрийг толгой зүтгүүрээс удирдах систем

Creep speed function for locomotives during train loading with overhead load-out bin – Ачилтын хурдны зүтгүүрийн таталтын систем

AAR – Стандартын бүрдэлд орсон
AS – Стандартын бүрдэлд орсон
GB – БНХАУ өөрийн стандартад нутагшуулсан
UIC – Практикт нь байхгүй учраас ороогүй байх магадлалтай

AAR – Стандартын бүрдэлд орсон
AS – Стандартын бүрдэлд орсон
GB – БНХАУ өөрийн стандартад нутагшуулсан
UIC – Практикт нь байхгүй учраас ороогүй байх магадлалтай

AAR – Стандартын бүрдэлд орсон
AS – Стандартын бүрдэлд орсон
GB – БНХАУ өөрийн стандартад нутагшуулсан
UIC – Практикт нь байхгүй учраас ороогүй байх магадлалтай

AAR – Стандартын бүрдэлд орсон
AS – Стандартын бүрдэлд орсон
GB – БНХАУ өөрийн стандартад нутагшуулсан
UIC – Байх ёстой

Цахилгаан удирдлагатай хийн тоормос

- Зүтгүүрийн компрессороос шахах агаар нь тоормосын хүчийг үүсгэнэ.
- Зүтгүүрт холбогдох цахилгаан кабелиар тоормос авах захирамж өгөгдөнө.

Үр дүн: Бүх вагон зэрэг тоормослох ажиллагаа хийгдэнэ.




< МТЗ ТӨХК-ын мэргэжилтэн Лхагвасүрэнгийн “Хүнд даацын, уул уурхайн төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний шилдэг техник технологиуд” сэдэвт судалгааны материалаас эш татав. >



Суурь бүтцүүдийн 2019 оны 4-8 дугаар сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгааны тайлан

2019 оны 4-р сарын 1-нээс 8-р сарын 31 хүртэлх хугацаанд нийтдээ 836 удаагийн зурмагийн тасалдал бүртгэгдсэнээс:




Зорчигчийн галт тэрэг:

- Явуулалтаар – 46 (5,5%)
- Өнгөрүүлэлтээр – 112 (13,36%)

Ачааны галт тэрэг:

- Явуулалтаар – 156 (18,66%)
- Өнгөрүүлэлтээр – 522 (62,44%)

Зорчигчийн галт тэрэгний явуулалтаар:




- Сүхбаатар
- Дархан
- Шарын гол
- Эрдэнэт
- Улаанбаатар
- Замын-Үүд
- Айраг

Сүхбаатар өртөө 17, Замын-Үүд өртөө 11, Дархан өртөө 8, Улаанбаатар өртөө 6, Эрдэнэт өртөө 2, Шарын гол болон Айраг өртөөнд тус тус 1 удаагийн тасалдал бүртгэгдсэн байна.

Зорчигчийн галт тэрэгний өнгөрүүлэлтээр:

Сүхбаатар-Улаанбаатар хэсэгт 45, Дархан-Улаанбаатар хэсэгт 15, Зүүнхараа -Улаанбаатар хэсэгт 2, Улаанбаатар-Сайншанд хэсэгт 14, Улаанбаатар-ЗамынҮүд хэсэгт 36 удаагийн тасалдал бүртгэгдсэн байна.



- Сүхбаатар - Улаанбаатар
- Дархан - Улаанбаатар
- Зүүнхараа - Улаанбаатар
- Улаанбаатар - Сайншанд
- Улаанбаатар - ЗамынҮүд

Шинэ технологийн судалгаа



Суурь бүтцийн 2019 оны 4-8-р сарын хөдөлгөөний зурмагийн тасалдлын судалгааны тайлан


Ачааны галт тэрэг явуулалтаар:

156 тасалдал (нийт тасалдлын 18,66%) бүртгэгдсэнээс хамгийн их тасалдал гарсан өртөөдөөс Сүхбаатар өртөө 34, Дархан өртөө 35, Зүүнхараа өртөө 18, Чойр өртөө 11, Сайншанд өртөө 15, Замын-Үүд өртөө болон Улаанбаатар-2 өртөө тус тус 8 удаагийн тасалдал гаргасан байна.



Ачааны галт тэрэг өнгөрүүлэлтээр:

Нийтдээ 522 тасалдал (нийт тасалдлын 62,44%) бүртгэгдсэнээс хамгийн их тасалдал гаргасан хэсгээс Улаанбаатар-Чойр хэсэг 135, Зүүнхараа-Улаанбаатар хэсэг 112, Сайншанд-ЗамынҮүд хэсэг 78, Чойр-Сайншанд хэсэг 75, Сүхбаатар-Зүүнхараа хэсэг 52 удаагийн тасалдал тус тус гаргасан байна.



Хамгийн их тасалдал гаргасан алба, аж ахуйн нэгжүүдийг авч үзвэл нийт тасалдлаас 254 нэгж буюу 30,38% нь ТЧ-2, 119 нэгж буюу 14,23% нь ТЧ-3, 84 нэгж буюу 10,04% нь ТЧ-1-д буюу 457 тасалдал (54,66%) зүтгүүрийн албанд бүртгэгдсэн байна. Мөн бусад шалтгаанаар тооцсон тасалдал 156 нэгж буюу нийт тасалдлын 18,66%-ийг эзэлж байна.



Зам, тээврийн салбарын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн туршлага солилцох хэлэлцүүлэгт төвийн төлөөлөл оролцлоо.

Зам, тээврийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн туршлага солилцох сургалт, хэлэлцүүлэг 2019 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр Авто тээврийн үндэсний төвд зохион байгуулагдаж манай байгууллагаас ТНУАСХ-ийн дарга Д.Төгсжаргал, Хүний нөөцийн мэргэжилтэн М.Оюун-Ундрам нар оролцож туршлага солилцлоо. Уг арга хэмжээгээр “Гурван шатны хяналтын үзлэг”-ийг зохион байгуулах журмыг мөрдөх цаашлаад зам тээврийн салбарт хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн туршлага солилцох бусаддаа хуваалцах арга хэмжээ болсон.



Төвийн ажилтнууд байгууллагын хамт олны харилцаа, хандлага, идэвхи зүтгэл, уур амьсгалын талаар харилцан ярилцлаа.

Хамт олны идэвхийг хөгжүүлэх, ажилтнууд хоорондоо бие биетэйгээ илүү ойлголцох зорилгоор 2019 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр “Хоолны цагийг хамт олондоо” сэдэвт нэг өдрийн өдөрлөг зохион байгуулж, ажилтнууд идэвхи санаачлагатай оролцсон. Ажилтнуудын дунд байгууллагын соёл, хувь хүнийг идэвхижүүлэх арга зам, удирдлагаас хүлээж буй мотиваци, шинэ санал санаачлагын талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлж, чөлөөт ярилцлага өрнүүлсэн. Уг арга хэмжээгээр цаашид идэвхижүүлэлтийн зөв арга хэлбэрийг хэрэгжүүлэх, хамт олны уур амьсгалыг сайжруулах хэрэгцээ байгааг олж тодорхойлж чадсан сайшаалтай арга хэмжээ болсон.






Мэдээ, мэдээлэл



Төмөр замын талаар ерөнхий ойлголт", "Төмөр замын гарц гарам, аюулгүй байдал" сэдэвтэй гар зургийн уралдаан зохион байгууллаа.

Ерөнхий боловсролын Ган зам 20-р сургуулийн Жавхлантагс багштай 6х ангийн сурагчдад "Төмөр замын талаар ерөнхий ойлголт", "Төмөр замын гарц гарам, аюулгүй байдал" сэдэвтэй гарын авлага тараан харилцан ярилцаж, тус сэдвийн хүрээнд гар зургийн уралдаан зохион байгууллаа. Гар зургийн уралдаанд бүтээлээ ирүүлсэн сурагчдаас шилдэг 3 хүүхдийг шалгаруулан өргөмжлөл гарын, бэлэг гардуулан өглөө.

Тус уралдаанд ирүүлсэн сурагчдын бүтээлээс ...





**Газар бизнес төвийн байр,
Тээвэрчдийн гудамж,
2-р хороолол, 1-р хороо,
Баянгол дүүрэг, 16052,
Улаанбаатар хот, Монгол улс**

